



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 39

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 350 дугаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/291 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж, үр дүнг тайлагнах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

(Засаг даргын Тамгын газрын дарга)

(1 дүгээр багийн Засаг дарга)

(2 дугаар багийн Засаг дарга)

(Эрүүл мэндийн төвийн дарга)

(3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

(Соёлын төвийн дарга)

(Цагдаагийн хэсгийн дарга)

(Газрын даамал)

Нарийн бичгийн дарга:

(Байгаль орчны мэргэжилтэн)

2.Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн, шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр Засаг даргын зөвлөлд тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Л.Бадамханд)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/219 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА